



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар бөг. Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.

Утас/Факс: (976) 7032 2073.

Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn

Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2025. 04. 08 № 3-5/228

танай _____ -ийн № _____ -Г


**СУМЫН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, үнэлгээний дүнг хүргүүлж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан албан хаагчдыг холбогдох мэдээллээр хангаж, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана уу.

Хавсралт 8 хуудастай

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА *Уржипүрэв* Т.ҮРЖИНПҮРЭВ



Д. Мөнхсайрууц

Хэрэгшилэгч Сайтруулма 6225 33 0305
Төлөөлөгч Тарган ажилмаж
2025-04-10.

**БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	96.4	0.5	→ ?
	2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	81.7		
	3.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	71.2		
Үнэлгээний дундаж		83.1	41.6	3.7
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	90.0	0.15	
	2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	83.4		
	3.Засаг даргын Тамгын газар болон бусад төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	88.1		
	4.Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	75.7		
Үнэлгээний дундаж		84.3	12.6	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн үнэлгээ	75.0	0.2	
	2.Шударга байдлын түвшний үнэлгээ	85.0		
	3.Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	97.5		
	4.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт	80.0		
	5.Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт	65.7		
Үнэлгээний дундаж		80.6	16.1	
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	46.7	0.15	→ ?
Үнэлгээний дундаж оноо		46.7	7.0	
Ерөнхий үнэлгээ:		73.7		

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээний хэлтсийн даргын 2025 оны 04 дугаар
сарын 07-ны өдрийн 316/АДБ дугаар
албан бичгийн хавсралт

ЗӨВЛӨМЖ

2025 оны 04 дүгээр сарын 07

Арвайхээр

Сумдын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны
үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тухай

Нэг. Зорилго

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Үндэслэл, арга зүй

Сумдын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

- Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- Засаг даргын Тамгын газар болон бусад төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

- Байгууллагын ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн үнэлгээ
- Шударга байдлын түвшний үнэлгээ
- Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт
- Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:

-Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 3 үзүүлэлт нийт үнэлгээний 50 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт 15 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 5 үзүүлэлт 20 хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт

туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ болох 1 үзүүлэлт 15 хувиар тус тус тооцсон болно.

Гурав: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Сумын Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн тайлагналт, бүртгэл, хяналтад авч буй байдалд хяналт-шинжилгээ хийж дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авахдаа аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/149 дүгээр захирамжаар батлагдсан "Хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, мэдээлэх, тайлагнах журам"-ын хэрэгжилтийг хангаж, бүртгэл хяналтыг сайжруулах;

-Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тогтмол гардаг шийдвэр, заалтыг тухай бүр нь хяналтаас хасах;

-Тайланг товч тодорхой гол үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах;

-Тайланг гаргахдаа үр дүн, үр нөлөөг сайтар тооцоолж тайлагнадаг байх. Тайланд нийтлэг гарч байгаа дутагдал нь зарим тохиолдолд хэт нуршуу, эсхүл хэтэрхий товчилж бичсэн агуулга гаргаагүй байхад үнэлгээг өндөр дүгнэсэн байна. Иймд тайлангийн чанарыг сайжруулах, тайланг нэгтгэх, дүгнэх үр чадварт албан хаагч бүрийг сургах, чадавхжуулах;

-Гүйцэтгэл сайжруулах болон байгууллагын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлэх.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3б дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу тайлагнах (Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн баталсан бөгөөд үүнийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

-Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тухайн сум, байгууллагад хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа суурь түвшинг хүрэх түвшинтэй харьцуулж, өссөн дүнгээр тайлагнах

-Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан хөтөлбөрөөс цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой арга хэмжээг сумын дунд болон богино хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгаж ажиллах

-Бодлогын баримт бичгийг тайлагнахдаа зорилтот түвшнийг тодорхойлоогүй, арга хэмжээг хэрэгжилтийн явцаар тайлагнаж байгаа нь үнэлгээ бодит бус, төлөвлөлтийн чанар хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:

-Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хяналтад авахдаа сумандаа хэрэгжүүлж болох, үр дүн гарах арга хэмжээг хяналтад авч, хэмжих нэгж, зарцуулах хөрөнгө, суурь түвшин, зорилтот түвшинг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжигдэхүйц байдлаар оны эхнээс төлөвлөж, хэрэгжилтийг батлагдсан журмын хавсралтын дагуу товч тодорхой тайлагнахад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

-Мөн хэрэгжилтийн тайланг уншиж танилцахад хийсэн ажлаа жагсаан бичсэн, үр дүн, тоон мэдээлэл хангалтгүй тайлагнасан. Мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хавсралтад заасан маягтын дагуу тайлагнаагүй байна.

Дөрөв. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Өвөрхангай аймгийн Засаг даргаас 19 сумын Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээг 11 бүлэг 176 арга хэмжээтэй байгуулсан бөгөөд дээрх бүлэг арга хэмжээний хүрээнд биелэлтийг тайлагнасан байна.

Өмнөх онд гэрээний биелэлт ирээгүй нэг сум байсан бол 2024 онд 19 сум 100 хувь гэрээний биелэлтийг ирүүлсэн нь сайшаалтай байна. Гэрээний биелэлтийг Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дүгээр тогтоолын 10б хавсралтаар шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшинтэй хамтатган тайлагнасан.

“Хамтран ажиллах гэрээ”-ний биелэлтийн зарим онцлог бүтээлч ажлуудыг дурдвал:

-Сумдууд E-Mongolia.mn үйлчилгээг иргэддээ 1004 төрлийн лавлагаагаар үйлчилж байна. Сумын хэмжээнд төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ жигдэрч, сумын Тамгын газар оператор ажилтнаар дамжуулан цахим үйлчилгээг нэг цэгээс үзүүлж байна.

-Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн ажлын хүрээнд сумдын насан туршийн суралцахуйн төвийн арга зүйч нарыг сургагч багшаар бэлтгэж төрийн албан хаагч, иргэдэд цахим үйлчилгээг танилцуулж, “Цахимд хэвшье” арга хэмжээг сурталчилж иргэд, байгууллагуудад тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлсэн байна.

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан аймгийн болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг сумдууд давуулан төвлөрүүлж биелүүлсэн.

-Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS6648:2016, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS4946:2019, Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ MNS5021:2019 стандартуудыг танилцуулан мөрдүүлж хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна гэх мэт

Анхаарах асуудлууд:

-Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг Захиалагч нь гэрээний хагас, бүтэн жилийн тайланд дүгнэлт хийж, жилийн тайланд нарийвчилсан үнэлгээ өгнө. Иймд гэрээний биелэлтийн хугацаанд анхаарах

-Гэрээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийг нь тайлагнаагүй, мөн зарим сумдын гэрээний биелэлтийг дүгнэхэд хүрсэн түвшинг хүрэх түвшинтэйгээ уялдуулж биелэлтээ тайлагнаагүй байна;

-Албан хэрэг хөтлөлтийн стандарт болон үг үсгийн алдаа, утга найруулгын ойлгомжгүй байдалд дүгнэлт хийх шаардлагатай байна;

-Хамтран ажиллах гэрээний арга хэмжээний биелэлтийн хугацаанд анхаарах **Тухайлбал:** гэрээний 1.1.4 дэх заалт “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолд заасны дагуу хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэх бодлого баримтлан ажиллах, энэ заалтын биелэлтийг улирал бүр гаргаж өгөхөөр заасан бөгөөд зарим сумд ирүүлээгүй байна;

-Сумд Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт арга хэмжээнийхээ дагуу бүрэн тайлагнаагүй алдаа гарсан. Жишээ нь: Дээд шатны байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээг хугацаанд нь тайлагнах хэмээн заасан арга хэмжээг зөвхөн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээтэй уялдуулж тайлагнасан;

-Мөн зарим биелэлтийн хувьд үр дүнг товч тодорхой 2000 тэмдэгтэд багтаагаагүй буюу хэт нуршуу үйл явцыг нэг бүрчлэн дурдаж тайлагнасан зэрэг анхаарах асуудлууд байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг батлуулан, төрийн албан хаагчийн сургалт хөгжлийг дэмжих, мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөрийн хүрээнд байгууллага бүр сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд

хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцон ажиллаж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

-Байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, биелэлтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу тайлагнах, авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлт, мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу тайланд тусгаж, үнэн зөв, бодитой, бүрэн тайлагнаж хэвших;

-Холбогдох тайлан, мэдээлэл, судалгааны үзүүлэлт бүрийг үнэн зөв, бүрэн гаргаж хэвших, үр дүн, өөрчлөлтийг бодит, хэмжихүйц байдлаар тодорхойлж, оновчтой товч, тодорхой тайлагнахад анхаарах;

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа дараах зүйлд анхаарал хандуулан тайлан бичих арга зүйдээ зөвлөмж болгон ашиглана уу.

-Байгууллагын өөрийн үнэлгээг заавал өгөх буюу байгууллага заавал хэрэгжилтээ үнэлэх;

-Шалгуур үзүүлэлт тооцох (“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн 5 дахь хэсгийн 4 үзүүлэлтийн дагуу шалгуур үзүүлэлтийг заавал тооцох);

-Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлуудаа тайлагнах (тайлан ирүүлэхдээ төлөвлөгөөг заавал ирүүлэх (файлаар)).

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон нутагт хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг тусгахдаа тодорхой бус байгаа нь төлөвлөлт хийхдээ тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн онд юу хийх шаардлагатайг бүрэн томъёолж гаргахгүй байна. Энэ нь арга хэмжээний томъёолол тодорхойгүй байхад тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшнээ юунд үндэслэж гаргаж байгааг тодорхой харах боломжгүй байна. Иймд цаашид эдгээр дутагдлыг гаргахгүй байх, албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүрэн хангаж ажиллахыг анхааруулж байна.

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт нь арга хэмжээний нэгэн адил шалгуур үзүүлэлт, төсөв, зорилтот түвшин гэх мэтээр нэг бүрчлэн томъёологдохоор журамд зохицуулалт хийгдсэн боловч байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уг томъёолол хийгдээгүй байх бөгөөд тайланд ч мөн адил тусгагдаагүй дутагдалтай байна. Иймд цаашид дээрх дутагдлыг залруулж, төлөвлөлтийг сайтар хийж, биелэлтийн тайланд үр дүнг тооцож ажиллахыг анхаарах;

-Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлангийн хувьд боловсруулалт, тайлагналтын чанар ерөнхийдөө хангалттай байгаагүй ч үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны чиглэлээ бүрэн тодорхойлж ажилласан байна. Цаашид төлөвлөлтөд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшний төлөвлөлт нь харилцан уялдаатай байх, тэдгээртэй уялдан биелэлт, үр дүнгээ тооцож тайлагнасан байхыг бүх байгууллага, албан хаагчид анхаарч ажиллахыг зөвлөж байна;

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгаас баримталж байгаа холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, аймгаас өгсөн чиглэл, арга хэмжээний төлөвлөлтийг өөрийн сум орон нутгийн онцлогт нийцүүлэн томъёолоход анхаарах;

-Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай, нэг арга хэмжээнд 2-оос доошгүй байхаар тодорхойлох;

-Албан хаагчийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төсөв тавигдсан арга хэмжээнүүдийн биелэлтийг тооцож тайлагнахдаа тухайн төсвийн гүйцэтгэлийг тусгаж тайлагнахгүй байгааг анхаарах;

-Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа гадаад хүчин зүйлээс шалтгаалж хэрэгжээгүй, эсвэл хэрэгжилт нь хойшилсон арга хэмжээг журмын дагуу заавал үнэлэх, хэрэгжээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдах, өмнөх онд тодорхой

шалтгааны улмаас хэрэгжээгүй арга хэмжээ байгаа бол шаардлагатай тохиолдолд дараа оны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх зэрэг журмаар зохицуулагдсан зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь:

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, хуваарилсан, төсөл, хөтөлбөрүүдийн ихэнх нь үр дүнтэй хэрэгжсэн боловч зарим хөрөнгийн чанар, ашиглалт, хадгалалт тааруу, удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ажлууд хангалтгүй байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулга авахдаа иргэдийг тэгш хүртээмжтэй оролцуулж, саналын хуудсыг хүртээмжтэй байдлаар тарааж, иргэдийг идэвхжүүлэхэд санаачилгатай ажиллах, сумын иргэдийн Төлөөлөгчдин Хурлаар батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын эрэмбэлсэн жагсаалтад иргэдийн өгсөн санал орсон эсэхийг иргэдэд бүрэн мэдээлж ажиллахад анхаарах нь зүйтэй байна.

Жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оноос Удирдлага мэдээллийн системээр 6 бүлэг, 12 үзүүлэлтээр аймгийн ажлын хэсэг, Сангийн яам цахимаар үнэлдэг болсон тул цаашид үнэлгээгээ нэмэгдүүлж, оноо алдсан үзүүлэлтүүдийг онцгой анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Тав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

Байгууллагын ил тод байдлын үнэлгээ:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 201 дүгээр тогтоол, 2022 оны "Журам батлах тухай" 352 дугаар тогтоолын дагуу 19 сумын 2024 оны нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг гаргалаа. Мэдээлэл хариуцагчийн 5 төрлийн 68 мэдээллийг ил тод байлгах үүргийн дагуу үнэлгээг нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх аргачлалын дараах 4 шалгуур үзүүлэлт болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас байгууллагуудын shilen.gov.mn сайтад байршуулсан нээлттэй мэдээллүүдэд өгсөн үнэлгээг харьцуулан гаргасан болно.

- 1."Мэдээллийн хүртээмжтэй байдал"-ыг (МХБ)
- 2."Хугацаандаа нийтлэгдсэн байдал"-ыг (ХНБ)
- 3."Мэдээллийн бүрэн бүтэн байдал"-ыг (МБББ)
- 4."Эх сурвалжийн тодорхой байдал"-ыг (ЭСТБ)

Сумдын үнэлгээнд үндэслэн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор доорх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Сумын сайт, shilen.gov.mn хариуцах албан хаагчдыг чиг үүргийн дагуу эзэнжүүлж, тухайн байгууллагын болон албан агагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;
- Мэдээллийг ил тод болгохтой холбоотой мэдлэг, ур чадваруудыг нэмэгдүүлэх;
- Shilen.gov.mn сайтад тухай бүр мэдээллээ шуурхай оруулж, мэдээ тайланг журамд заасан хугацаанд илгээх;
- Ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглах;
- Нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтлэх, байршуулсан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлт оруулснаас хойш ажлын гурван өдрийн дотор өөрчлөлтийг тусгаж, мэдээллийг шинэчлэн нийтлэх;
- Мэдээллийг цахим хэлбэрээр байршуулахдаа хэрэглэгчийн өнцгөөс тэдэнд мэдээлэл хайх, хүлээн авах талаас нь бодолцон сайжруулах;
- Хэрэглэгчдээс ирж буй сэтгэгдэл, санал хүсэлтүүд болон цахим хуудасны хандалтуудад жил, улирлаар шинжилгээ хийж, цахим мэдээллийн ил тод байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Шударга байдлын түвшний үнэлгээ:

Сумдууд цахим сайтдаа авлигын чиглэлээр цэс нээж, тодорхой мэдээллүүдийг байршуулсан хэдий ч нийтлэг алдаа дутагдал байна.

Тухайлбал: Урд оны мэдээллээ шинэчлээгүй, үүсгэсэн цэсний нэр болон байршуулсан мэдээлэл зөрүүтэй, ач холбогдолгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан, цэс үүсгэж мэдээлэл байршуулсан гэх боловч Авлигатай тэмцэх гарзрын болон шилэн данс, холбогдох яамны сайтыг шууд холбосон зэрэг мэдээллийн шинэчлэл, баяжилт хангалтгүй байна.

-Цаашид цахим сайтад байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол шинэчилж байх;

-Авлигын чиглэлээр өдөр тутмын хийсэн ажлуудаа тогтмол оруулах;

-Сумдын Засаг даргаас төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр, мөн авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд сургалтын менежер, нягтлан бодогч нарыг хамруулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулдаг болсон тул энэ чиглэлээр тодорхой заалт тусган цэцэрлэг, сургуулийн удирдлагуудтай дээрх албан тушаалтнууд өөрчлөгдөх, солигдох, ажлаас чөлөөлөгдөх тухай бүр сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэн, ХАСУМ хянуулах;

-Томилогдсоны дараа 30 хоногт ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой заалт тусган, үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй байна.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

-Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт оруулах мэдээллийг бүрэн оруулж байхыг холбогдох хуулийн этгээдэд шаардлага тавин аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газартай хамтран ажиллах, мэргэшлийн зөвлөгөө өгөх;

-Улирлын тайланг хугацаанд нь илгээх, илгээхгүй байх тохиолдлыг цаашид арилгах,

-Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагуудын мэдээ оруулалт, тайлан илгээлтэд хяналт тавьж ажиллах;

-Бусад төсвийн байгууллагуудын мэдээ оруулалт, тайлан илгээлтэд хяналт тавьж ажиллах.

2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт:

-Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулж ажилласан сайн талтай ч төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлээгүй байна;

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт хувийн хэрэг нээж, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасаж, байнгын шинжтэй шийдвэрүүдийг хяналтад авч, тайлагнан ажиллаж байна гэсэн боловч, тоо баримт, дүн мэдээлэлгүй тайлагнасан байна;

-Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах;

-Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичиг стандарт (MNS 5140:2021)-ын хэрэгжилтийг хангаж ажиллах. Тухайлбал: Хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас зэргийг стандартын шаардлагад нийцүүлэх;

-2025 онд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулагдахтай холбогдуулан ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах.

Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт:

-Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд шилжин ирэгсдийг нэмэгдүүлэх зорилгоор сум, орон нутгаа сурталчилсан, давуу талаа харуулсан контент богино хэмжээний шторк болон ярилцлага нэвтрүүлгүүдийг цувралаар хийж олны хүртээл болгох шаардлагатайгаас гадна

шилжин суурьшигчдын сэтгэгдлийг сайн жишээ болгон олон нийтэд түгээж ажиллах нь зүйтэй байна;

-Мөн шилжин ирсэн иргэд, бага насны хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, ажлын байр, хөнгөлттэй зээлд хамрагдсан иргэдийн судалгааг тодорхой гаргаж тайлагнаж хэвших;

-Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд арга хэмжээний төлөвлөгөөг жилийн эхнээс төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж, журмын дагуу иж бүрэн, тайлагнахад анхаарах. ✓

Зургаа: Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 11 дүгээр хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт"-ийг баталсан бөгөөд журмын 6.2.1 дэх заалтыг баримтлан үнэлэв. "Тэрбум мод" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлангийн үнэлгээнд харгалзуулан тооцсон.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх болон хог хаягдлыг бууруулах чиглэлээр явуулж буй сургалт, сурталчилгаа, нөлөөллийн аяны хөрөнгө санхүүг нэмэгдүүлэх, жил бүр сумын нийт хүн амын 20-30 хувийг бүрэн хамруулж байхаар төлөвлөж байх.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

-Газрын тухай хуульд заасан өөрийн эзэмшил, өмчлөлийн газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгах заалтыг хэрэгжүүлж ажиллах;

-Нийтийн эзэмшлийн зам талбайд тарих мод бутны нэр төрлийг нэмэгдүүлж, таналт тайралтын ажлыг тогтмолжуулан, жимс жимсгэний мод бутаар агро ойжуулалт хийх;

-Ногоон байгууламжийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг онол практик хослуулан хийж, хашаа хороогоо тохижуулсан жишиг айл өрх, гудамжийг олноор бий болгоход анхаарах;

-Усалгаа арчилгаа хариуцсан иргэдийн хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ усалж арчилсан мод бутны амьдралтын хувийг харгалзан урамшуулал олгох;

-Ойн тухай хуулийн 31.1.1 т заасан 16 насанд хүрсэн иргэн бүр нэг аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана гэсэн заалтын дагуу "Ногоон байгууламж нэмэгдүүлэх" журам боловсруулж мод бут тарих санхүүжилтийг нэмэгдүүлэх.

Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг эхлүүлж, хоёрдогч түүхий эд цуглуулах төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах;

-Хөдөөгийн зам даваа, уул овооны хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн аян, нийтийн цэвэрлэгээг улирал бүр хийж хэвших

-Айл өрхүүдэд хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав, ариун цэврийн байгууламжийн жишиг загварыг гаргаж сурталчлах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСЭГ